

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2023.05.10-НЫ ӨДРИЙН А-91 ТООТ  
ТУШААЛААР БАТЛАГДСАН “ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЖУРАМ”-ЫН  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

2024.06.17

1. “Төлбөрийн системийн журам”-д дараах заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулах.

1/ 1 дүгээр зүйлийн 1.22 дахь заалт:

“1.22. Картын мэдээллийг токен буюу 16-19 орон бүхий үл давтагдах тоон дараалалаар орлуулах, тухайн токеныг картын мэдээллээр эргүүлэн солих нь токенжуулах үйлдэл байна.”

2/ 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн 3.2.6 дахь заалт:

“3.2.6. Цахим хэтэвчинд зөвхөн олон улсын стандартын дагуу үүсгэсэн токен ашиглах, гүйлгээ илгээх;”

3/ 5 дугаар зүйлийн 5.32 дахь заалт:

“5.32. Төрийн үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авсны шимтгэл нь 1,500 (нэг мянга таван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.”

4/ 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.13 дахь заалт:

“6.1.13. Оператор нь системийн дүрэмд болон системийн оролцогчийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц өөрчлөлтийг өөрийн системд хийх тохиолдолд ажлын 20-оос доошгүй өдрийн өмнө нийт оролцогч нарт болон Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан ёсоор мэдэгдэж, холбогдох зааврыг хүргүүлнэ.”

2. Журмын 5 дугаар зүйлд дараах заалтуудыг дор дурдсанаар нэмэх.

1/ 5.32 дахь заалт:

“5.32<sup>1</sup>. Орон сууцны хэрэглээний төлбөрийг картаар хүлээн авсны шимтгэл нь 300 (гурван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.”

2/ 5.36 дахь хэсгийн 5.36.8 дахь заалт:

“5.36.8. Ухаалаг цахим төхөөрөмжид суулгасан картын токенжуулсан мэдээллээр хийгдэх гүйлгээг тухайн ухаалаг цахим төхөөрөмж нь нууц дугаар оруулах, хурууны хээ, царай таних гэх мэт аргаар баталгаажуулна. Ингэж баталгаажуулсан гүйлгээнд ПОС төхөөрөмж нь давхар ПИН код шаардахгүй.”

3. Журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.6 дахь заалт “6.1.6. Энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн аудитаар жилд нэг удаа баталгаажуулна.” гэснийг хасах.